


Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн
хувьцаа эзэмшигчийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.



- 1.1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь (цаашид "компани" гэх) Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, Банкны харилцах данстай, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, тусгайлан эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх эдэлж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг, шүүх, арбитрын өмнө өөрийн өмнөөс оролцдог хуулийн этгээд байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагддаг нээлттэй хувьцаат компани байна.
- 1.2. Компанийн оноосон нэр: "АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК байх ба англиар "ARD FINANCIAL GROUP" Joint Stock Company буюу товчилсон байдлаар "ACH ХК", англиар "AFG JSC" гэж нэрлэнэ.
- 1.3. Компанийн бэлгэдэл тэмдэг нь  гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь санхүүгийн нэгдэл гэж бичсэн байна.
- 1.4. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
- 1.5. Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, хоёр давхар.

ХОЁР. КОМПАНИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1. Компани нь дараах зорилгыг ханган ажиллана. Үүнд:
 - 2.1.1. Бид Монгол Улсын хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани байхыг зорьж ажиллах бөгөөд Хөрөнгө оруулагчдын санхүүгийн өгөөжийг зохистой түвшинд байлгахын тулд ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэртэй барих бодлогыг чиглэл болгон ажиллана.
 - 2.1.2. Улс орны эрх ашиг болон хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчийнхээ эрх ашгийг хамгаалах, ажилчдын ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэн илүү их ашиг хуваарилах зэрэг болно.
- 2.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:
 - 2.2.1. Хөрөнгө оруулалт;
 - 2.2.2. Бизнесийн зөвлөгөө;
- 2.4. Компани нь тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагаагаа явуулахдаа эрх бүхий байгууллагаас зохих журмын дагуу холбогдох тусгай зөвшөөрөл авч бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Компани нь Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.
- 3.2. Компани нь өөрийн үйл ажиллагаагаа зөвхөн бие даасан байдлаар эсвэл дотоод, гадаадын хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 3.3. Компани үйл ажиллагаагаа Монгол улсын Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд явуулна.
- 3.4. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох хөрөнгө оруулалт нь ТУЗ-ийн удирдлага, хяналтын дор явагдах бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал шийдвэрлэн хэрэгжүүлнэ.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

- 3.5 Компани нь өөрийн нэрийн барааны тэмдэг, эмблем, бэлэг тэмдэгтэй албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга, тэмдэг хэрэглэнэ. Бэлэгдэл барааны тэмдгийг Оюуны өмчийн газар бүртгүүлж тэдгээрийн хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.
- 3.6 Компани нь үйл ажиллагааны чиглэлээс хамаарч охин болон хараат компани, салбар төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
- 3.7 Компани үндсэн үйл ажиллагаандaa мэргэжилдээ туршлагатай, үр чадвартай хүмүүсийг хөдөлмөрийн хуулинд нийцүүлэн гэрээгээр авч ажиллуулан тэдний цалин урамшуулал, ажиллах нөхцлийг нь тогтооно.
- 3.8 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.
- 3.9 Компани нь өөрийн бизнес үйл ажиллагаатай холбоотой зүйлийг хуулийн дагуу нууцалж болно.
- 3.10 Компани нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахтай холбогдуулан сан байгуулж болно.
- 3.11 Компани нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтөлж эсхүл үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ХАРИУЦЛАГА

- 4.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
- 4.2. Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчид нь компанийн хариуцлагыг өөрийн эзэмшилийн хувьцааны хэмжээгээр хүлээнэ.
- 4.3. Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү хариуцсан захирал, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал, Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал, Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан захирал, Дотоод аудитор, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн нарийн бичгийн дарга нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанийд учруулсан хохирлыг хариуцна.
- 4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. Компанийн энгийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 5.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь гэрээ, дүрэм журмын заалтыг хэлбэрэлтгүй сахиж, компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлэх, компанийн нууцад хамааралтай бүхий л зүйлийг чандлан хадгалж, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол гэрээгээр хүлээсэн үүрэг, хөдөлмөрийн хуулийг чанд биелүүлэх, компанийн үнэт цаас эзэмшиж байгаа этгээд нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хетлэх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хүлээнэ.
- 5.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.
- 5.4. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:
 - 5.4.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн
хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

- 5.4.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
- 5.4.3 Компанийн үйл ажиллагааг зогсоох үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- 5.4.4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах;
- 5.4.5 Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувь ЦАЭЗЭМШИГЧИЙН БҮРӨӨРҮҮЛЭН ЭЗЭМШИЖ БАЙГАА ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН АВАХЫГ КОМПАНИАС ШААРДАХ ЭРХТЭЙ. Үүнд:
 - 5.4.5.1 Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах болсон бол;
 - 5.4.5.2 Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;
 - 5.4.5.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
 - 5.4.5.4 Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанийд хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- 5.4.6. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид нь ХЭХ-ын бүрэн эрхийн асуудлаар саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд санал гаргах;
- 5.4.7. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
- 5.4.8. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- 5.4.9. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.
- 5.4.10. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

**ЗУРГАА. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА БУСАД ҮНЭТ ЦААС, ТҮҮНИЙГ ГАРГАХ,
ХУДАЛДАХ БОЛОН ЭРГҮҮЛЭН АВАХ**

- 6.1. Компани нь 1,000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 28,614,263 ширхэг зарласан хувьцаатай байна. Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, бүртгэлийг хөтлүүлнэ.
- 6.2. Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно:
 - 6.2.1 Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн
хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

- 6.2.2 Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох;
- 6.3. Компани нь энгийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.
- 6.4. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо нэрлэсэн үнэ, үнийн дүн, гаргах хугацаа нөхцөл зэргийг заасан байна.
- 6.5. Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ бизнес эрхлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 6.6. Гаргасан үнэт цаас болон хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ шийдвэрлэнэ.
- 6.7. Компанийн тодорхой тооны энгийн хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдаж авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Опционоор худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах тухай шийдвэрийг ТУЗ, түүнээс их бол ХЭХ-аар шийдвэрлэнэ. Шийдвэрт опцион гаргах болсон үндэслэл, гаргах опционы тоо, опцион эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдан авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционы үнэ зэргийг заасан байна.
- 6.8. Хувьцаа бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 6.9. ТУЗ-ийн шийдвэрээр компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.
- 6.10. Компани нь дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж болно.
- 6.10.1. Хуульд заасан үүргийнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;
- 6.10.2. Үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;
- 6.10.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их бол.
- 6.11. Компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.
- 6.12. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "ХЭХ" гэх) байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 7.3. ТУЗ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх, хяналт тавих журам"-ыг баталж мөрдүүлнэ.
- 7.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ-өөс зарлаж хуралдуулах бөгөөд Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргаж хуралдуулна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн
хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

- 7.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулна.
- 7.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 7.7. Энэхүү дүрмийн 7.4 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан шийдвэрт тусгагдсан хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ХЭХ-ыг даргалах боломжгүй болсон тохиолдолд энэ тухайгаа Төлөөлөн Удирдах Зөвлөлд мэдэгдэх ба Төлөөлөн Удирдах Зөвлөл хурлын даргыг хурал болохоос өмнө дахин томилно.
- 7.8. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход Компанийн тухай хуулийн 71.5, 72.1.3, 72.2, 77.1-т тус тус заасны дагуу санал хураалтын кумулятив аргаар явуулна.
- 7.9. Дүрмийн 7.9¹-д зааснаас бусад Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын энгийн олонхийн санаалаар шийдвэрлэнэ.
- 7.9¹. Компанийн тухай хуулийн 62.1.1-62.1.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
- 7.10. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна.
- 7.11. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 68 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуулийн 63-64 дүгээр зүйлд зааснаар бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.
- 7.12. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүний хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байна.
- 7.13. Компанийн саналын эрхтэй хувьцааны энгийн олонх хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуудах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаас хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй болно.
- 7.14. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.-д заасан журмын дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дунд тооцно.
- 7.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.
- 7.16. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.
- 7.17. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал төрөлж эхлийг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.
- 7.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэ дүрмээр ХЭХ-ийн бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- 8.1.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
 - 8.1.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;
 - 8.1.3. 100 хувийн эзэмшлийн охин болон хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэх;
 - 8.1.3¹. 100-аас бага хувь эзэмшдэг охин болон хараат компанийн ХЭХ-д оролцож АСН ХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг ТУЗ-өөс томилох;
 - 8.1.4. Компанийн тухай хууль болон хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.
 - 8.1.5. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох, гүйцэтгэлийг ХЭХ-д танилцуулах.
 - 8.2. Компанийн ТУЗ нь 9-өөс 11 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.
 - 8.3. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-өөс түүний оронд өөр хүнийг түр томилно.
 - 8.4. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн санал хураалтын дийлэнх олонхийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн үүрэг гүйцэтгэнэ.
- ТУЗ-ийн дарга нь:
- 8.4.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих үүрэгтэй.
 - 8.5. ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн дотоод журмаар тогтооно. Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.
 - 8.6. ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор хороодтой байна. Эдгээр хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
 - 8.7. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
 - 8.8. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
 - 8.9. ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу төлөөлөн удирдах зөвлөлөөр сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.
 - 8.10. ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана.
 - 8.11. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
 - 8.12. 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд ТУЗ-ийн Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажлын туршлага, мэргэжлийн үр чадварыг үндэслэн холбогдох шийдвэр, зөвлөмжийг гаргана.
 - 8.13. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
 - 8.13.1 Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

- 8.13.2 Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байна;
- 8.13.3 ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх;
- 8.13.4 Өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх;
- 8.13.5 ТУЗ-ийн хуралд идэвхитэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог дайчлах, хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнах үүрэгтэй.
- 8.14. Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Аудитын хороо 2. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, 3. Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороог тус тус байгуулан ажиллуулна.
- 8.15. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 8.15.1 Компанийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү зэдийн застийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 8.15.2 Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, ТУЗ-д танилцуулах;
- 8.15.3 Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- 8.15.4 Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх (чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ);
- 8.15.5 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 8.15.6 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 8.16. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.16.1 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- 8.16.2 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн үр чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд энэхүү дүрмийн 8.13-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 8.16.3 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- 8.16.4 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 8.16.5 Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- 8.16.6 ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- 8.16.7 Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах;
- 8.16.8 Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
- 8.16.9 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 8.16.10 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулалт олгох санал боловсруулах;

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн
хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

- 8.16.11** Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дунг үнэлэх;
- 8.16.12** Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
- 8.17.** Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 8.17.1** Компанийн стратеги төлөвлөгөөг судалгааны үндсэн дээр боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 8.17.2** Санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтед нийцсэн эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, шинээр хийгдэх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд стратегийн эрсдэмлийн урьдчилан дүгнэлт гаргах, чиглэл, зөвлөмж боловсруулах;
- 8.17.3** Компанийн үнэ цэнийг тодорхойлж, хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 8.17.4** Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж стратегийн удирдамж чиглэлээр хангаж ажиллах ба дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, томоохон гэрээ хэлцэлүүд, компанийн өөрчлөн байгуулалт (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах г.м) зэрэгт хяналт тавьж ажиллана;
- 8.17.5** Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 8.18.** ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, идэвхи хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүнийг чөлөөлөгдөх өргөдлөө өгөхийг шаардаж болно.
- 8.18¹.** Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно.

ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 9.1.** Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 9.2.** Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.
- 9.3.** Гүйцэтгэх захирал нь Зохицуулалттай хуулийн этгээдээс бусад хараат болон охин компанийн Гүйцэтгэх захиралыг нэр дэвшиүүлэх, санал болгох эрхтэй.
- 9.4.** Гүйцэтгэх удирдлагын төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх удирдлагын эфх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 9.5.** Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 9.6.** Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.
- 9.7.** Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.
- 9.8.** ТУЗ Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоо шийдвэрийг хэдийд ч гаргаж болно.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

- 9.9. Гүйцэтгэх захирлын жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана.

АРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ, ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

- 10.1. Компанийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргаж баталгаажуулах бөгөөд тайланг хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.
- 10.2. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 сарын 01-нээс 12 сарын 31-нд дуусгавар болно.
- 10.3. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.
- 10.4. Санхүүгийн тайлан нь Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.
- 10.5. Ногдол ашиг хуваарилалтын шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах “бүртгэлийн өдөр” болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 10.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашигийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

- 11.1. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- 11.2. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар аудитын хороо нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатай сонгогдоно.
- 11.3. Аудитын хорооны бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдэд тавих шаардлага зэргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулах бөгөөд бусад зүйлсийг аудитын хорооноос баталсан дотоод журмаар зохицуулна.
- 11.4. Аудитын хороо нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.
- 11.5. Аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.
- 11.6. Аудитын хороо нь аудитын тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг ТУЗ-өөр батлуулна.
- 11.7. Гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 11.8. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудитын байгууллагын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.
- 11.9. Компанийн жилийн санхүүгийн тайланда дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 11.10. Дараах этгээдийг компанийн дотоод аудитор болон аудитын байгууллагаар сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
- 11.10.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрт нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн 20/02 тоот тогтоолоор тус тус батлав.

11.10.2. компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрхийг эзэмшдэг бол;

11.10.3. компанийн аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

11.11. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагaa, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

12.1. Компанийг ХЭХ-ын шийдвэрээр буюу Компанийн хуульд заасан бусад үндэслэлээр өөрчлөн байгуулах (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн зохион байгуулах замаар) өөрчлөн байгуулж болно.

12.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

12.3. ХЭХ-ын шийдвэрээр компанийг татан буулгах ажиллагааг ТҮЗ-өөс томилогдсон Татан буулгах комисс, хэрэв шүүхийн шийдвэрээр татан буугдаж байгаа бол шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

12.4. Дор дурьсан үндэслэлээр шүүх компанийг татан буулгана

12.4.1. Компани дампуурсан;

12.4.2. Нэг ч гишүүн үлдээгүй;

12.4.3. Хуульд заасан бусад үндэслэл;

12.5. Компанийг татан буулгах тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангасны дараа үлдсэн хөрөнгө (үүний дотор компанийн эд хөрөнгийг борлуулсны орлого мөн орно)-ийг Компанийн хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

12.6. Компанийг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буулгасанд тооцно.

АРВАН ГУРАВ. БУСАД НӨХЦӨЛҮҮД

13.1. Энэхүү дүрэмд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын дийлэнх олонхийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

13.2. Энэхүү дүрэм болон холбогдох журамд шууд заагаагүй аливаа асуудлыг тухайн үед нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль болон эрх зүйн бусад актаар зохицуулна.

13.3. Энэхүү дүрэм нь УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж Компани үйл ажиллагаагаа зогсоох буюу өөрчлөн байгууллагдах хүртэл хугацаагүй үйлчилнэ.

13.4. Энэхүү дүрэм нь Монгол хэл дээр З хувь үйлдэж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт, татварын албанад тус тус нэг нэг хувийг, компанийд нэг хувийг хадгална.

